

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 20.5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 2 дахь хэсэг нэмсүгэй:

1/20.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтын “байлдааны галт зэвсэг,” гэсний дараа “сум,” гэж, 20.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төхөөрөмжийг хууль бусаар бэлтгэсэн” гэсний дараа “, эсхүл сум хууль бусаар үйлдвэрлэсэн, дахин цэнэглэсэн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны ... сарын ..-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 12, 13, 14 дэх хэсэг нэмсүгэй:

1/5.6 дугаар зүйлийн 12, 13, 14 дэх хэсэг:

“12.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь тусгай зориулалтын буудлага үйлдэх байгууламжид буудлага үйлдүүлэхдээ аюулгүй ажиллагааны болон буудлага үйлдсэн этгээдийн бүртгэлийн журам зөрчсөн бол нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Хууль сахиулах болон байлдааны зориулалттайгаас бусад галт зэвсэгт дуу намсгах хэрэгсэл, байлдааны зориулалттай шөнийн болон дулаан мэдрэгчтэй харааны хэрэгсэл суурилуулсан, нийтэд худалдаалсан, импортлосон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, иргэнийг нэг мянган нэгжтэй, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Монгол Улсад галт зэвсэг, сум нийтэд худалдах төв, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл борлуулах борлуулагч, спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, тээвэрлэх, худалдах, аюулгүй байдлыг хангах журам зөрчсөн бол таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг дор дурснаар өөрчлөн найруулсугай:

1/5.6 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“10.Спорт-сургалт, ан агнуурын, харуул хамгаалалт, үзмэр цуглуулгын зориулалтаар галт зэвсэг, сум улсын хилээр нэвтрүүлэх, худалдаалах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “эзэмших” гэсний дараа “худалдах,” гэж, мөн зүйлийн 9 дэх хэсгийн “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” гэсний дараа “галт зэвсэг, сумыг хурааж,” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Иргэний” гэснийг “ан агнуур, спорт-сургалт, үзмэр цуглуулга” гэж, мөн хэсэг, мөн зүйлийн 3, 4, 5, 6, 11 дэх хэсгийн “дөчин” гэснийг “нэг зуун” гэж, мөн хэсгүүдийн “дөрвөн зуун” гэснийг “нэг мянган” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “хүнийг гурван” гэснийг “хүнийг таван” гэж, мөн хэсгийн “этгээдийг гурван” гэснийг “этгээдийг таван” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн “арван” гэснийг “хорин” гэж, “нэг” гэснийг “хоёр” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтыг доор дурснаар өөрчлөн найруулсугай:

1/ 4дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт:

“4.1.14. “ангийн буу” гэж Галт зэвсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т заасныг;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... сарын ..-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах 5,6,7,8,9 дэх хэсэг нэмсүгэй:

1/29 дүгээр зүйлийн 5,6,7,8,9 дэх хэсэг:

“5.Байгаль хамгаалагч нь боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна. Сануулга өгөх нь цаг алдаж хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг шууд хэрэглэж болно.

6.Байгаль хамгаалагч галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэхдээ аль болох хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахгүй байвал дараах арга хэмжээг шат дараатай авах үүрэг хүлээнэ:

1/энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан тохиолдол бий болсон үед галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бэлэн байдалд авах;

2/тухайн хүнд галт зэвсэг, галт хэрэгсэлтэй адилтгах хэрэгсэл хэрэглэх тухай сануулах, тодорхой зай, байр тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглох;

3/энэ зүйлийн 5-д заасны дагуу урьдчилан сануулсны дараа тухайн хүн бусдын амь насанд ноцтойгоор халдах үйлдлээ үргэлжлүүлсэн тохиолдолд галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг хэрэглэх.

7.Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэсний улмаас хүн гэмтсэн тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ. Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэглэсэн тохиолдол бүрд прокурор, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

8.Байгаль хамгаалагч галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, хүний биед учирсан гэмтэл, үзүүлсэн тусламж, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдсэн тухай болон бусдын эд хөрөнгөд хохирол учирсан эсэх талаар шууд захирах даргадаа даруй танилцуулж, бичгээр тайлбар үйлдэх бөгөөд шууд захирах дарга нь прокурор, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

9.Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.”

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Галт зэвсгийн тухай хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ

галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг байгууллагын даргын зөвшөөрлөөр биедээ авч явах эрхтэй.”

2/29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“Байгаль хамгаалагч галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэхдээ Прокурорын тухай хуулийн ... заасан зааврыг баримтална.”

3 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын байцаагч, байгаль” гэснийг тус тус “Байгаль” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “резинэн болон цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн буюу хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл” гэснийг “нэг бүрийн тусгай хэрэгсэл болон галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2026 оны ... сарын ...-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурснаар өөрчлөн найруулсугай:

1/32 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэхэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийг баримтална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... сарын ..-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

ГАЛТ ЗЭВСГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3 дахь заалт:

3	Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл	10 000
---	----------------------------------	--------

2 дугаар зүйл. Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “галт зэвсэг” гэсний дараа “, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны ... сарын ..-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг “галт зэвсгийг” гэснийг “галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны ... сарын ..-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. сарын ..-ны
өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “11.1,” гэсний дараа “11.2,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... сарын ..-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг